



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

A/35

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын "Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх тухай" 2017 оны А/д01 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголчуудын оршихуйн соёлын нэн үнэт өв "Угийн бичиг"-ээ үеэс үе дамжуулан үр хүүхэддээ өвлүүлэн уламжлах, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сурталчилах, өрх бүрээр хөтлүүлэх, бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Угийн бичиг хөтлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Дашлонжид-Соёлын төвийн дарга
Нарийн бичгийн дарга: Н.Орхонтуул-Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Гишүүд: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга
Н.Батжаргал-1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч
Ж.Тогоохүү-2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч
О.Отгонболд-Эрүүл мэндийн төвийн дарга
Г.Дуламдорж-Насан туршийн боловсролын арга зүйч
Г.Цэрэндулам-Нийгмийн бодологын мэргэжилтэн
Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга
Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга
С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга
Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга
Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга

2. Сум, багийн түвшинд "Угийн бичиг хөтлөх" ажлыг эрчимжүүлэн сурталчилах, сургалт, арга зүй, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, төрийн албан хаагч бүр өөрийн удмын "Угийн бичиг"-ийг хөтөлж, ойр дотны ахан дүүс, найз нөхдийн хүрээнд 5 өрхийг сонгон "Угийн бичиг"-ээ хөтөлж хэвшүүлэхэд дэмжиж ажиллахыг Байгууллагын дарга, эрхлэгч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийн явцыг жилд 2 удаа Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын төвийн эрхлэгч (Д.Дашлонжид)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН